

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2023/10

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.X	2022.X	2023.IX	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 3-р улирал	их наяд ₮, оны үнээр	46.5	35.2	46.5	-	-	-	6.9% ▲
Инфляц	хувь	9.0	14.5	10.1	0.3% ▲	-	6.7% ▲	-5.5 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин, 2023УЗ	хувь	5.2% 2023 оны УЗ	5.4% 2022 оны У2	5.8% 2023 оны У2	-	-0.6% ▼ нэгж хувиар	-	-0.2% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	2062	-1019	2158	-96 ▼	-	-	3080 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3452.50	3369.90	3466.08	-13.58 ▼	-	-	82.6 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	4914.4	2864	4540.7	374 ▲	-	-	2051 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	52	23.1	48.9	-51% ▼	-	-	2.2 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1272	1093.4	1200	-6% ▼	-	-	6% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	12%	13%	0%	-	0%	1% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.9	2.8	4.1	-4% ▼	-	-	43% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	8.29%	11.65%	8.43%	-0.14 нэгж хувиар ▼	-	-	-3.36 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Монгол Улсын 2024 оны төсвийг батлав	Төсвийн төсөөлөлд 2024 оны төсвийн төсөөллийг боловсруулахдаа эдийн засгийн өсөлт ирэх онд 7 хувьтай, инфляц 8.5 хувь байхаар төсөөлжээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ: 25.9 их наяд буюу ДНБ-ий 34.2%, Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн: 27.4 их наяд буюу ДНБ-ий 37%, Төсвийн тэнцэл: -1.5 их наяд буюу ДНБ-ий -2.0% байхаар баталлаа.
ДНБ-ий хэмжээ 6.9 хувь өсөв	2023 оны 3-р улиралд ДНБ-ий хэмжээ оны үнээр 46.5 их наяд төгрөгт хүрч, 6.9 хувиар өслөө. Үүнд Уул уурхай олборлолтын салбар 28.6 хувь, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбар 66.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Монгол Улсын Засгийн газрын шийдвэр	2023/11/06	- 2024.04.01-с Тэтгэвэрийн хэмжээг 100,000 төгрөгөөр нэмэх - Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 660,000 төгрөгт хүргэв

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард 14.5 хувь гарсан бол 2023 оны 10 дугаар сард 9.0 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар буурсан байна. Улсын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 3.2 нэгж хувиар (35.6%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 4.5 нэгж хувиар (50.0%) тус тус нөлөөлсөн байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 10 дугаар сард 3452.5 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 82 төгрөгөөр чангарч, өмнөх сараас 13.58 төгрөгөөр суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 4%-иар буурч, өнгөрсөн жилийн мөн үеэс 43%-иар өсөж, 3.9 тэрбум ам.долларт хүрээ.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 19.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.7 (40.2%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 19.0 их наяд төгрөгт хүрч, 6.0 (46.2%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 оны эхний 10 сард 16.9 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2023 оны эхний 10 сард нийт 161 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 20.0 тэрбум америк долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 12.5 тэрбум америк доллар, импорт 7.6 тэрбум америк доллар болж, тэнцэл 4.9 тэрбум америк долларын ашигтай гарсан байна. 2023 оны эхний 10 сард экспорт өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум америк доллароор өсөхөд нүүрс 2.0 тэрбум америк доллар, газрын тос 136.9 сая америк доллар, жоншны хүдэр ба баяжмал 132.1 сая америк доллар, лаазалсан махан бүтээгдэхүүн 114.5 сая америк доллар, адууны мах 96.1 сая америк доллар, молибдений хүдэр, баяжмал 30.1 сая америк доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.

Эх сурвалж: Олон улсын валютын сан

- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа N⁰

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 10-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 10-р сар 2023 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn